



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 12 дугаар сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, энэхүү хуулийг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

[/Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хууль, 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.

3.2. Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг дагаж мөрдөнө.

3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахтай холбогдсон харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

[/Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн, энэ хэсэгт 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

3.4. Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

[/Энэ хэсэгт 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

3.5. Хууль тогтоомжоор олгосон эрхийн дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх улсын чанартай авто замын засвар, арчилгаатай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.

3.6. Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

[/Энэ хэсгийг 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

3.7. Зөвлөлдөх санал асуулга болон сонгуулийн төв байгууллагаас Сонгуулийн тухай хуулийн 38.1-д заасан төсвийн хүрээнд сонгууль зохион байгуулахтай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар

зөхицуулахгүй.

[/Энэ хэсгийг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

[/Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

3.8. Ирээдүйн өв сан, Ирээдүйн өв сан корпорацийн үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

[/Энэ хэсгийг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

3.9. Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд тусгайлан заасан мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой үнэт цаас, валют худалдан авах, мөнгөн тэмдэгт хэвлүүлэх, хадгалуулах, тээвэрлэх, гадаад валютын улсын нөөцийг бүрдүүлэхтэй холбогдуулан гадаад валют, алт худалдан авах, цэвэршүүлэх, тээвэрлэх, банкны хяналт, шалгалтын хүрээнд зөвлөх үйлчилгээ авах, үндэсний төлбөрийн системийн программ хангамж, түүний тоног төхөөрөмж, эрдэнэсийн нөөц санг бүрдүүлэхэд хамаарах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

[/Энэ хэсгийг 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

3.10. Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авахтай холбоотой үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

3.11. Төрийн аудитын тухай хуульд заасан аудитад шинжээч оролцуулж, зөвлөх үйлчилгээ авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

[/Энэ хэсгийг 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

3.12. Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх нийслэл хотын хот тохижилт, авто замын засвар, арчилгаа, хог хаягдалтай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

[/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

3.13. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд заасан хяналт, шалгалтыг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхэд мэргэшсэн этгээдийг оролцуулж, зөвлөх үйлчилгээ авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

[/Энэ хэсгийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

4 дүгээр зүйл. Захиалагч

4.1. Дараахь этгээд захиалагч байна:

4.1.1. төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

4.1.2. 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;

4.1.3. Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.21-д заасан төсөл хэрэгжүүлэгч.

5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

5.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1. “тендер” гэж захиалагчийн тогтоосон нөхцөл, шаардлагын дагуу боловсруулж, түүнд ирүүлсэн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх тухай сонирхогч этгээдийн саналыг;

5.1.2. “тендер шалгаруулалт” гэж хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг энэ хуульд заасан журмын дагуу шалгаруулж, бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээ байгуулах эрх олгох, гэрээ байгуулах ажиллагааг;

5.1.3. “босго үнэ” гэж бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгөөс хамааруулан тендер шалгаруулалтыг энэ хуульд заасан журмын дагуу явуулахад баримтлах үнийн дээд, эсхүл доод хязгаарыг;

5.1.4. “тендерийн урилга” гэж захиалагчаас тендер шалгаруулалт явуулах тухай мэдэгдсэн, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан баримт бичгийг;

5.1.5. “тендерийн баримт бичиг” гэж захиалагчаас тендер оролцогчид зориулан гаргасан тендер шалгаруулалтын нөхцөл, шаардлагыг тодорхойлсон баримт бичгийг;

5.1.6.“тендерт оролцогч” гэж захиалагчаас хараат бус дараахь этгээдийг ойлгоно:

5.1.6.а.дангаараа тендер ирүүлсэн этгээд;

5.1.6.б.хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендер ирүүлсэн хэд хэдэн этгээд;

5.1.7.“тендерийн баталгаа” гэж гэрээ байгуулах хүртэл, эсхүл тендерийн хүчинтэй байх хугацаа дуустал тендер хүчин төгөлдөр байх, шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах, хариуцлагатай оролцохоо баталгаажуулж тендерт оролцогчоос захиалагчид ирүүлсэн банкны баталгаа, даатгагчийн баталгаа, Засгийн газрын бонд, Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасыг;

[/Энэ заалтад "банкны баталгаа," гэсний дараа "даатгагчийн баталгаа," гэж 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ заалтад 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

5.1.8.“урьдчилгаа төлбөрийн баталгаа” гэж захиалагч урьдчилгаа төлбөр төлөх тохиолдолд уг төлбөрийг гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах үүргээ баталгаажуулж гүйцэтгэгчээс захиалагчид ирүүлсэн банкны баталгаа, даатгагчийн баталгаа, Засгийн газрын бонд, Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасыг;

[/Энэ заалтад "банкны баталгаа," гэсний дараа "даатгагчийн баталгаа," гэж 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

5.1.9.“үнэлгээний хороо” гэж энэ хуульд заасан журмын дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулах зорилгоор захиалагчийн байгуулсан ажлын хэсгийг;

5.1.10.“бараа” гэж эдийн засгийн ач холбогдол, үнэ бүхий худалдаж, солилцож болох зүйл болон тухайн барааг нийлүүлэхэд шаардагдах ажлыг. Ажлын үнэ нь барааны үнээс их байвал тухайн гэрээг “ажлын гэрээ” гэж тооцно;

5.1.11.“ажил” гэж барилга байгууламжийн ажил, барилгын тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил, түүнчлэн тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа нийлүүлэлтийг. Бараа нийлүүлэлтийн үнэ нь ажлын үнээс их байвал тухайн гэрээг “барааны гэрээ” гэж тооцно;

5.1.12.“барилга байгууламжийн ажил” гэж барилга байгууламжийг барих, өргөтгөл, шинэчлэлт, их засвар болон өрөмдлөг, хайгуул хийх зорилгоор хүн хүч, машин техник, тоног төхөөрөмж, материал, технологийг хослуулан ашиглаж гүйцэтгэх ажлыг;

5.1.13.“тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил” гэж энэ хуулийн 5.1.11-д зааснаас бусад тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт, тохируулга хийх ажлыг;

5.1.14.“үйлчилгээ” гэж зөвлөх үйлчилгээ болон бусад үйлчилгээг;

5.1.15.“зөвлөх үйлчилгээ” гэж гүйцэтгэгчээс төсөл зохиох, хэрэгжүүлэх, сургалт явуулах, техникийн туслалцаа үзүүлэх, түүнчлэн судалгаа шинжилгээ хийх, зураг төсөл боловсруулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих тусгай мэдлэг, үр чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээг;

5.1.16.“түлхүүр гардуулах гэрээ” гэж барилга байгууламжийн зураг төсөл, инженерийн тооцоо, тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулан, уг барилга байгууламжийг ашиглалтад бэлэн болгохтой холбогдсон хоорондоо уялдаа холбоо бүхий хэд хэдэн ажил, бараа, үйлчилгээг бүхэлд нь хамарсан нэг гэрээг;

5.1.17.“гүйцэтгэлийн баталгаа” гэж гэрээ байгуулах эрх авсан тендерт оролцогч гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хангахыг баталгаажуулж, гэрээнд гарын үсэг зурахаас өмнө захиалагчид ирүүлсэн банкны баталгаа, даатгагчийн баталгаа, Засгийн газрын бонд, Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасыг;

[/Энэ заалтад "банкны баталгаа," гэсний дараа "даатгагчийн баталгаа," гэж 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

5.1.18.“гэрээ байгуулах эрх олгох” гэж хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой худалдан авах гэрээ байгуулах тухай захиалагчийн шийдвэрийг түүнд мэдэгдэхийг;

5.1.19.“техникийн тодорхойлолт” гэж захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн үзүүлэлт, үйлдвэрлэл, үйл ажиллагааны арга, технологи, түүнд тавих технологийн шаардлагыг тодорхойлсон бүрдүүлбэрийг;

5.1.20.“Монгол Улсын гарал үүсэлтэй бараа” гэж Монгол Улсад олборлосон, ургуулсан, бойжуулсан, үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл хийж бүтээсэн бараа буюу эд ангиудын дийлэнхийг угсарч, түүний үндсэн шинж чанар,

зориулалт, ашиглалтын хэлбэрээс илт өөр болгосон шинэ барааг;

5.1.21.“гадаадын этгээд” гэж энэхүү хуульд заасан журмын дагуу худалдан авах үйл ажиллагаанд оролцохыг сонирхож байгаа гадаад улсын болон олон улсын байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнийг хэлнэ;

[/Энэ заалтыг 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

5.1.22.“бага үнийн арга” гэж захиалагчийн тогтоосон техникийн саналд авбал зохих доод оноотой тэнцүү буюу түүнээс дээш оноо авсан зөвлөхүүдээс хамгийн бага үнэ санал болгосон зөвлөхийг шалгаруулахыг;

5.1.23.“ерөнхий гэрээ” гэж захиалагч нь байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээг нэг ба түүнээс дээш нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй 3 хүртэл жилийн хугацаанд үнэ болон бусад нөхцөлийг тохирч байгуулсан гэрээг.

[/Энэ заалтыг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

5.1.24.“өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээ” гэж зөвхөн тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардагдах бараа, ажил, үйлчилгээг;

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.1.25.“худалдан авах ажиллагааны цахим систем” гэж цахим программ хангамжийг ашиглан худалдан авах ажиллагааг төлөвлөх зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих цогц үйл ажиллагаа, мэдээллийн тогтолцоог;

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.1.26.“цахим худалдан авах ажиллагаа” гэж худалдан авах ажиллагааны цахим системийг ашиглан зохион байгуулах худалдан авах ажиллагааг;

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.1.27.“цахим дэлгүүр” гэж ерөнхий гэрээний дагуу бараа, үйлчилгээг худалдан авахад зориулсан худалдан авах ажиллагааны цахим системийн бүрэлдэхүүн хэсгийг;

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.1.28.“ногоон худалдан авах ажиллагаа” гэж эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг;

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.1.29.“урьдчилсан худалдан авах ажиллагаа” гэж Улсын Их Хурал улсын төсөв батлах, гадаад улс, олон улсын байгууллагатай байгуулах зээл, тусламжийн олон улсын гэрээг соёрхон батлахаас өмнөх шатанд улсын төсөв, зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг урьдчилан зохион байгуулахыг.

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.1.30.“даатгагчийн баталгаа” гэж Даатгалын тухай хуулийн 4.1.13-т заасныг.

[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

6 дугаар зүйл.Худалдан авах ажиллагааны зарчим

6.1.Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

7 дугаар зүйл.Худалдан авах ажиллагааны журам

7.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна:

7.1.1.нээлттэй тендер шалгаруулалтын журам;

7.1.2.тендер шалгаруулалтын онцгой журам;

7.1.3.зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам.

7.1.4. олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам.

[Энэ заалтыг 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

7.2. Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө.

[Энэ хэсэгт 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

7.3. Захиалагч энэ хуулийн 8.1.2-т заасан босго үнээс бага төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан журмыг мөрдөхгүйгээр шууд худалдан авч болно.

7.4. Захиалагч гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар сонгон шалгаруулж болно.

[Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7.5. Энэ хуулийн 7.4-т заасан урьдчилсан худалдан авах ажиллагааны журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

[Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7.6. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээний жагсаалтыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.

[Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7¹ дүгээр зүйл. Худалдан авах ажиллагаан дахь олон нийтийн оролцоо

7¹.1. Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан төвлөрүүлэн захирагч нь холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрснөөр харьяалагдах байгууллагын төсвийн хүрээнд худалдан авах нэг төрлийн бараа, ажил, үйлчилгээг нэгтгэн, нийлүүлэгч болон гүйцэтгэгчийг нь сонгон шалгаруулж болно.

7¹.2. Сум, дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах хорин сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж болно.

7¹.3. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам, заавар, жишиг баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж мөрдүүлнэ.

7¹.4. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан сонгон шалгаруулалт явуулах бөгөөд тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд орон нутгийн иргэдийг өргөнөөр оролцуулах зарчмыг баримтална.

[Энэ зүйлийг 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

8 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааны журмыг сонгох

8.1. Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараахь босго үнийг тогтооно:

8.1.1. харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;

8.1.2. шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;

8.1.3. зөвлөх сонгох бага үнийн аргыг хэрэглэж болох зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;

~~8.1.4. төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрөл олгох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн доод хязгаар;~~

[Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон/](#)

8.1.5. энэ хуулийн 52.1.12-т дурдсан цахим хуудсанд тендерийн урилгыг зарлан мэдээлэх бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн доод хязгаар.

8.2. Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.

8.3. Хэрэглээний үнийн индекс 10-аас дээш хувиар өөрчлөгдөх тухай бүр энэ хуулийн 8.1-д заасан босго үнийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шинэчлэн тогтооно.

[Энэ хэсэгт 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

8.4. Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

8.5. Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

8.6.Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно.

8.7.Захиалагч энэ хуулийн 8.6-д зааснаар тендер шалгаруулалтыг багцад хувааж явуулахдаа дараахь шаардлагыг хангана:

8.7.1.тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох;

8.7.2.захиалагч тендерийн урилга болон тендерийн баримт бичигт багцуудын талаарх мэдээлэл, тендерт оролцогч нэг буюу хэд хэдэн, эсхүл бүх багцад саналаа ирүүлж болохыг заах;

8.7.3.багц тус бүрт үнэлгээ хийх;

8.7.4.тухайн тендер шалгаруулалтын дүнгээр байгуулах бүх гэрээний үнийн дүнгийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.

8.7.5.энэ хуулийн 10¹.1-д заасан дотоодын үйлдвэрээс авах боломжтой барааг импортын бараанаас тусад нь багцлах.

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

8.8.Гэрээ байгуулах эрхийг багц тус бүрээр, эсхүл хэд хэдэн багцаар буюу бүх багцаар олгож болно.

8.9.Тендерт оролцогч нэг этгээдэд нэгээс дээш багц бараа, ажил, үйлчилгээгээр гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсэн бол энэ тухай худалдан авах ажиллагааны тайланд дурдана.

8.10.Зураг төсөл, барилга угсралт, тохируулгын ажлыг энэ хуулийн 5.1.16-д заасан журмаар түлхүүр гардуулах гэрээгээр гүйцэтгүүлэхээр бүхэлд нь тендер зарлаж болно.

[/Энэ хэсгийг 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

8.11.Бараа, үйлчилгээг ерөнхий гэрээ байгуулан худалдан авахаар тендер зарлаж болно.

[/Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

8.12.Ерөнхий гэрээ байгуулах журам, зааврыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

8.13.Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно.

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

8.14.Захиалагч ерөнхий гэрээний дагуу худалдан авахаас бусад жил бүр давтагддаг ажил, зөвлөхийн бус үйлчилгээний нэгж үнэ болон бусад нөхцөлийг гурав хүртэл жилийн хугацаанд тогтоосон тендер шалгаруулалт зохион байгуулан гэрээ байгуулж болно.

[/Энэ хэсгийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

9 дүгээр зүйл.Тендер шалгаруулалтад гадаадын этгээдийг оролцуулах

9.1.Гадаадын этгээд энэ хуульд заасан журмын дагуу тендер шалгаруулалтад оролцох эрхтэй.

9.2.Захиалагч нь 10,000,000,001 төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажил, 100,000.001 төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий бараа, үйлчилгээний тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцохыг хориглож үл болно.

[/Энэ хэсэгт 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

9.3.Энэ хуулийн 9.2-т зааснаас бусад тендер шалгаруулалтад гадаадын этгээдийг оролцуулж үл болно.

[/Энэ хэсгийг 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

10 дугаар зүйл.Тендер оролцогчдод давуу эрх олгох

10.1.Захиалагч тендерийн үнэлгээ хийхдээ дараахь этгээдэд давуу эрх олгоно.

10.1.1.Монгол Улсын гарал үүсэлтэй болон хог хаягдал дахин боловсруулсан бараа нийлүүлэх тендер ирүүлсэн этгээд;

10.1.2. 50-иас доошгүй хувийг нь бие даан гүйцэтгэхээр ажил гүйцэтгэх тендер ирүүлсэн дараахь этгээд:

10.1.2.а.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд;

10.1.2.б.Монгол Улсад бүртгэлтэй, өмчийнх нь 50-иас доошгүй хувь нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хувь хөрөнгөөс бүрдсэн гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд;

10.1.3.нийслэл, дүүрэг, улсын зэрэглэлтэй хотод хамаарахгүй орон нутагт үйлдвэрлэсэн бараа, материал, үзүүлж байгаа үйлчилгээг хамгийн ихээр ашигласан;

[/Энэ заалтад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

10.1.4.нийслэл, дүүрэг, улсын зэрэглэлтэй хотод хамаарахгүй орон нутгаас хамгийн их ажиллах хүч авсан.

[/Энэ заалтад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

10.1.5.хуулийн этгээдийн ажиллах хүчний 90-ээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байх.

[/Энэ заалтыг 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

10.1.6.инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын аж ахуйн нэгж.

[/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

10.1.7.ажиллах хүчний 30 ба түүнээс дээш хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн эзэлдэг, 25 ба түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж.

[/Энэ заалтыг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

10.2.Энэ хуулийн 10.1.1, 10.1.3, 10.1.6-д заасан этгээдэд давуу эрх олгох бол түүний ирүүлсэн тендерийн Монгол Улсын гарал үүсэлтэй барааны хэсгийн үнийг 10 хувиар, энэ хуулийн 10.1.1-д заасан этгээд нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5.1-д заасан жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч бол түүний ирүүлсэн тендерийн Монгол Улсын гарал үүсэлтэй барааны хэсгийн үнийг 15 хувиар, энэ хуулийн 10.1.2, 10.1.4, 10.1.7-д заасан этгээдийн ажил гүйцэтгэх тендерийн үнийг 7.5 хувиар хийсвэрээр бууруулж тооцон бусад оролцогчийн тендерийн үнэтэй харьцуулж үнэлнэ.

[/Энэ хэсэгт 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

10.3.Энэ хуулийн 10.2-т заасны дагуу нийлүүлэх бараа, гүйцэтгэх ажлын тендерийн үнийг хийсвэрээр тооцон үнэлсэн нь энэ хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.6, 10.1.7-д заасан этгээдийн тендерийн үнийг бууруулах, өөрчлөх үндэслэл болохгүй.

[/Энэ хэсэгт 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

10.4.Тендерийн үнэлгээ хийхдээ энэ хуулийн 10.1-д заасан этгээдэд давуу эрх олгох бол энэ тухай тендерийн баримт бичигт тодорхой заах бөгөөд давуу эрх эдлэхийг хүссэн тендер оролцогч барааны гарал үүсэл, өртгийн талаархи мэдээлэл, эсхүл энэ хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.6, 10.1.7-д заасныг нотлох баримтыг ирүүлнэ.

[/Энэ хэсэгт 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

10.5.Давуу эрх олгох аргачлал, зааврыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10¹ дүгээр зүйл. Дотоодын үйлдвэрээс бараа худалдан авах

10¹.1.Чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой тохиолдолд тендер шалгаруулалтад гадаадын бараа нийлүүлэгчийг оролцуулахыг хориглоно.

[/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

10¹.2.Энэ хуулийн 10¹.1-д заасан дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтыг үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

10¹.3.Энэ хуулийн 10¹.1-д энэ хуулийн 9.2 дахь хэсэг хамаарахгүй.

[/Энэ зүйлийг 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

10¹.4.Засгийн газар дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтыг баталсан тогтоолын хэрэгжилт, үр дүнд жил бүр үнэлгээ, шинжилгээ хийж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр оруулна.

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

11 дүгээр зүйл. Техникийн тодорхойлолт

11.1.Захиалагч техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ дараахь шаардлагыг хангасан байна:

11.1.1.тухайн бараа, ажил, үйлчилгээг гадаад шинж чанарын үзүүлэлтээр бус, зориулалт, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээ, ашиглалт, чанарын түвшин, техникийн болон тухайн бараа, ажил, үйлчилгээ нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлох;

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

11.1.2.үндэсний стандарт, техникийн шаардлага, норм, норматив, дүрэм, зааварт үндэслэх, үндэсний стандарт, техникийн

норм байхгүй тохиолдолд Монгол Улсын хүлээн зөвшөөрсөн олон улсын стандартад үндэслэх;

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

11.1.3.барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөл тавихгүй;

11.1.4.энэ хуулийн 11.1.3-т заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэх.

11.2.Захиалагч техникийн тодорхойлолт бэлтгэхдээ тухайн тендер шалгаруулалтад оролцох сонирхолтой этгээдээс өрсөлдөөнийг хязгаарлахад хүргэж болох зөвлөгөө авахыг хориглоно.

12 дугаар зүйл.Тендерт оролцогчийн чадварыг үнэлэх

12.1.Тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавхи болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадлана.

12.2.Захиалагч тухайн тендер шалгаруулалтад тавигдах чадавхийн шалгуур үзүүлэлт, шаардлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд нийцүүлэн тогтоож, тендерийн баримт бичигт тусгана.

12.3.Энэ хуулийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн тогтоосон чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй тендерээс татгалзаж, энэ тухай тендер ирүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

12.4.Захиалагч «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоос өмнө энэ хуулийн 12.2-т заасан чадавхийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг дахин магадлаж болно.

12.5.Захиалагч тендерт оролцогчийн чадавхийг магадлах явцад олж мэдсэн түүний техникийн болон бизнесийн нууцыг хадгална.

13 дугаар зүйл.Урьдчилсан сонголт явуулах

13.1.Захиалагч тендер ирүүлэхээс өмнө тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдийн чадавхийг магадлах зорилгоор урьдчилсан сонголт явуулж болох бөгөөд ингэхдээ дараахь журмыг баримтална:

13.1.1.тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдийн чадавхийн шалгуур үзүүлэлт, түүнд тавигдах шаардлага, тэдгээрийг хангасныг нотлох баримтыг тусгасан урьдчилсан сонголтын баримт бичгийг бэлтгэх;

13.1.2.урьдчилсан сонголт явуулах тухайгаа энэ хуулийн 21.1-21.4-т заасны дагуу зарлан мэдээлэх;

13.1.3.урьдчилсан сонголтын баримт бичигт заасан чадавхийн шалгуур үзүүлэлтийг хангасан оролцогчид тендер ирүүлэхийг мэдэгдэх.

13.2.Урьдчилсан сонголт явуулах үед энэ хуулийн 17.1, 21.1, 21.3, 21.4-т заасан “тендерийн урилга”-ыг “урьдчилсан сонголтын урилга”, энэ хуулийн 19, 22, 23-т заасан “тендерийн баримт бичиг”-ийг “урьдчилсан сонголтын баримт бичиг” гэж тус тус ойлгож хэрэглэнэ.

13.3.Урьдчилсан сонголт явуулах журам, зааврыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

14 дүгээр зүйл.Ерөнхий нөхцөлийг магадлах

14.1.Дараахь нөхцөл байдал тогтоогдвол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ:

14.1.1.төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор эзэлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;

14.1.2.Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;

14.1.3.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг;

14.1.4.сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, энэ хуулийн 52¹.1-д заасан эрх бүхий улсын байцаагч тогтоосон;

14.1.5.тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;

14.1.6.илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг энэ хуулийн 52¹.1-д заасан эрх бүхий улсын байцаагч тогтоосон;

14.1.7.сүүлийн 3 жилийн хугацаанд авилгалын гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон.

14.2.Өөрийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр тухайн жилд зарлагдсан тендер шалгаруулалтад хуулийн этгээд зургаагаас дээшгүй удаа оролцож болох бөгөөд үүнээс 3 удаад тендер нь шалгарсан бол тухайн жилд дахин тендер шалгаруулалтад оролцохыг хориглоно.

14.3.Энэ хуулийн 14.1-д заасан нөхцөл байдал үүссэн болохыг тендерт оролцогч Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын дараахь баримт бичгээр нотолж болно:

[/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

14.3.1.шүүхийн шийдвэр болон төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичиг;

14.3.2.үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээ болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг.

14.4.Энэ хуулийн 14.3-т заасан баримт бичгээс тухайн тендер шалгаруулалтад ирүүлэх шаардлагатай баримт бичгийг тендерийн баримт бичигт тусгайлан заана.

14.5.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 14.1.4, 14.1.6 дахь заалтад заасан нөхцөл үүссэнийг тогтоосон тухай энэ хуулийн 52¹.1-д заасан эрх бүхий улсын байцаагчийн шийдвэрийг үндэслэн тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтөлж, нийтэд мэдээлнэ.

[/Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

14.6.Тендерт оролцогч энэ хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ.

14.7.Захиалагч шаардсан тохиолдолд тендерт оролцогч хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаархи мэдээллийг бичгээр ирүүлнэ.

14.8.Захиалагч энэ зүйлийн 14.7-д заасан мэдээллийг тендерт оролцогчийн тухайн гэрээг гүйцэтгэх санхүүгийн болон техникийн чадавхийг үнэлэхэд харгалзан үзнэ.

15 дугаар зүйл.Санхүүгийн чадавхийг үнэлэх

15.1.Захиалагч тендерт оролцогчоос гэрээний үүргийн биелэлтийг хангах санхүүгийн чадавхитайгаа баталсан нотолгоо ирүүлэхийг шаардаж болно.

15.2.Захиалагч санхүүгийн чадавхийн шаардлагыг тендерийн, эсхүл урьдчилсан сонголтын баримт бичигт тусгана.

15.3.Санхүүгийн чадавхийг дараахь баримт бичгээр нотолж болно:

15.3.1.харилцагч банкны мэдэгдэл;

15.3.2.тендерт оролцогчийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт;

15.3.3.зөвлөхийн орон тоо, цалин, бусад зардлын тооцооны хүснэгт;

15.3.4.тендерт оролцогчийн сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй бараа, ажил, үйлчилгээний жилийн борлуулалтын талаархи мэдээлэл.

15.4.Энэ хуулийн 15.3-т заасан баримт бичгээс тухайн тендер шалгаруулалтад ирүүлэх баримт бичгийг тендерийн баримт бичигт заана.

16 дугаар зүйл.Техникийн чадавхи болон туршлагыг үнэлэх

16.1.Тендерт оролцогчийн техникийн чадавхи, туршлагыг ажил, бараа, үйлчилгээний агуулга, онцлог, тоо хэмжээг харгалзан дараахь үзүүлэлтийн аль нэгийг үндэслэн тогтооно:

16.1.1.тендерт оролцогчийн удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар;

16.1.2.сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт;

16.1.3.сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд нийлүүлсэн бараа, үйлчилгээ, тэдгээрийн үнийн дүн, хугацаа болон худалдан авагчдын жагсаалт, шаардлагатай бол бараа, үйлчилгээний гүйцэтгэлийн талаархи өмнөх худалдан авагчдын тодорхойлолт;

16.1.4.тендерт оролцогчийн багаж, техник хэрэгслийн тодорхойлолт, үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмжийн жагсаалт;

16.1.5.чанарын хяналтыг шууд, эсхүл туслан гүйцэтгэх гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэх чанарын хяналтын арга хэмжээ;

16.1.6.нийлүүлэх барааны загвар, тодорхойлолт, эсхүл гэрэл зураг, тэдгээрийн үнэн болохыг гэрчилсэн баримт бичиг;

16.1.7.барааны хувьд эрх бүхий байгууллагаас олгосон чанарын гэрчилгээ, үйлдвэрлэгчийн итгэмжлэл.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан баримт бичгээс тухайн тендер шалгаруулалтад ирүүлэх шаардлагатай баримт бичиг, тэдгээрт тавигдах шаардлагыг тендерийн баримт бичигт заана.

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

17 дугаар зүйл.Нээлттэй тендер шалгаруулалт

17.1.Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана.

17.2.Тендерт оролцох сонирхолтой этгээд нь захиалагчаас тогтоосон хугацаанд техникийн болон санхүүгийн саналыг хамтад нь ирүүлнэ.

17.3.Энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтыг нэг үе шаттай явуулна.

18 дугаар зүйл.Хоёр үе шаттай нээлттэй тендер шалгаруулалт явуулах

18.1.Захиалагч нээлттэй тендер шалгаруулалтыг дараахь нөхцөлд хоёр үе шаттай явуулж болно:

18.1.1.ажлын цар хүрээ их, төсөвт өртөг өндөртэй болон цогцолбор буюу хоорондоо уялдаа холбоо бүхий хэд хэдэн бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэх гэрээ байгуулах шаардлагатай бөгөөд техникийн тэгш бус санал ирэх магадлалтай, эсхүл өгөгдсөн шаардлагыг хангах, ижил хэмжээнд хүлээн зөвшөөрөхүйц хоёр, түүнээс дээш техникийн шийдэл байх боломжтой гэж захиалагч үзсэн;

18.1.2.захиалагч техникийн тодорхойлолтыг урьдчилан тогтоох боломжгүй бөгөөд ажлын цар хүрээг эцэслэн тогтоох, техникийн тодорхойлолт бэлтгэхэд туршлагатай гүйцэтгэгч, нийлүүлэгчээс туслалцаа авах шаардлагатай.

18.2.Хоёр үе шаттай нээлттэй тендер шалгаруулалтыг дараахь байдлаар явуулна:

18.2.1.тендерт оролцогч нь техникийн саналаа ирүүлэх бөгөөд түүнийг захиалагч үнэлж, нэмж оруулах тодотгол, өөрчлөлтийг тендерт оролцогчтой тохиролцох;

18.2.2.тодотгол, өөрчлөлт оруулсан техникийн саналыг үндэслэн хийсэн санхүүгийн саналаа тендерт оролцогч ирүүлэх бөгөөд энэхүү тодотгосон саналыг захиалагч үнэлэх.

18.3.Захиалагч хоёр үе шаттай нээлттэй тендер шалгаруулалт явуулах тухайгаа тендерийн баримт бичиг болон урилгад заана.

19 дүгээр зүйл.Тендерийн баримт бичиг бэлтгэх

19.1.Захиалагч тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам, аргачлалын дагуу бэлтгэнэ.

19.2.Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана.

20 дугаар зүйл.Тендерийн баталгаа

20.1.Захиалагч энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш өртөгтэй бараа, ажил, зөвлөхийн бус үйлчилгээ, 100 сая төгрөгөөс дээш өртөгтэй зөвлөх үйлчилгээ худалдан авах тендерт оролцогчоос тендерийн баталгаа ирүүлэхийг шаардана.

[/Энэ хэсэгт 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

20.2.Монгол Улсын хуулийн этгээд тендерийн баталгааг банкны болон даатгагчийн баталгаа, Засгийн газрын бондын хэлбэрээр, гадаадын хуулийн этгээд Монгол Улсын буюу гадаадын банкны баталгаа, Монгол Улсын буюу гадаадын даатгагчийн баталгаа, Монгол Улсын Засгийн газрын бонд, эсхүл Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр ирүүлж болно.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.3.Гадаадын хуулийн этгээд тендерийн, гүйцэтгэлийн, урьдчилгаа төлбөрийн баталгаа болгон ашиглаж болох үнэт цаасны жагсаалтыг Засгийн газар тогтооно.

20.4.Захиалагч тендерийн баталгааны хэмжээг төсөвт өртгийн 0.5 хувиар тогтоож тендерийн баримт бичигт тусгана.

[/Энэ хэсгийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

20.5.Тендерийн баталгаа шаардсан нөхцөлд түүнийг ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн тендерийн баталгаа нь энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй бол захиалагч тухайн тендерээс татгалзана.

20.6.Захиалагч «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой гэрээ байгуулсны дараа тендерийн баталгааг хүчингүй болгоно.

20.7.Дараахь тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгоно:

20.7.1.тендерт оролцогч тендерийг нээсний дараа, тендерийн хүчинтэй хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс татгалзсан;

20.7.2.«хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэлд заасан хугацаанд гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй, эсхүл гэрээ байгуулахаас татгалзсан.

20.7.3.тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

21 дүгээр зүйл.Тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэх

21.1.Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

[/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

21.2.Захиалагч тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод, нээлттэй зарлах бөгөөд сонирхсон этгээдэд саадгүй олгоно.

21.3.Энэ хуулийн 9.2-т заасан этгээдийн тендерийн урилгыг олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг хэл дээр гардаг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

[/Энэ хэсэгт 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

21.4.Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан цахим хуудсанд байрлуулж тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ.

[/Энэ хэсэгт 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

21.5.Тендерийн урилгад дараахь мэдээллийг тусгана:

21.5.1.захиалагч байгууллагын тодорхойлолт;

21.5.2.худалдаж авах бараа, ажил, үйлчилгээний товч агуулга;

21.5.3.тендерийн баримт бичиг, бусад мэдээлэл авах, тендер ирүүлэх хаяг;

21.5.4.тендерийн баримт бичгийн үнэ;

21.5.5.тендер шалгаруулалтад тавих тусгай шаардлага;

21.5.6.тендер хүлээн авах эцсийн хугацаа;

21.5.7.тендер нээх хугацаа;

21.5.8.гадаадын этгээдийг оролцуулах эсэх;

21.5.9.давуу эрх олгох эсэх.

22 дугаар зүйл.Тендерийн баримт бичиг, тэдгээртэй холбоотой мэдээллийг олгох

22.1.Захиалагч тендерийн баримт бичгийг тендерийн урилга нийтлэгдэх өдрөөс өмнө бэлэн болгосон байх үүрэгтэй.

22.2.Захиалагч тендерийн баримт бичгийн үнийг тендер зохион байгуулах үйл ажиллагааны бодит зардлыг үндэслэн тогтоож тендерт оролцохыг сонирхсон этгээдэд уг үнээр саадгүй худалдана.

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

22.3.Тендерт оролцогч тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээллийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын таваас доошгүй хоногийн өмнө захиалагчаас авах хүсэлтийг бичгээр гаргаж болно.

22.4.Захиалагч энэ хуулийн 22.3-т заасан хүсэлтийн хуулбарыг түүнд өгсөн хариу тодруулга, нэмэлт мэдээллийн хамт тендерийн баримт бичиг худалдан авсан бүх сонирхогчдод нэгэн зэрэг бичгээр илгээх бөгөөд уг бичгийг шуудангийн байгууллагад хүлээлгэн өгснөөр, эсхүл худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлснээр хариу тодруулга, нэмэлт мэдээллийг хүргүүлсэнд тооцно.

[/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

23 дугаар зүйл.Тендерийн баримт бичиг, урилгыг гадаад хэл дээр бэлтгэж, тараах

23.1.Тендерийн баримт бичиг, урилгыг дараахь тохиолдолд монгол хэлээс гадна олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг хэл дээр бэлтгэж болно:

[/Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

23.1.1.энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол;

23.1.2.бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг, шинж чанар гадаадын этгээдийн сонирхлыг татна гэж захиалагч үзэж байгаа бол.

24 дүгээр зүйл.Тендер ирүүлэх болон хүчинтэй байх хугацаа

- 24.1.Захиалагч тендерт оролцогчдод тендер бэлтгэж ирүүлэх хангалттай, ижил хугацаа олгоно.
- 24.2.Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацааг тендер шалгаруулалтыг анх зарлан мэдээлсэн өдрөөс эхлэн тооцож тогтооно.
- 24.3.Нээлттэй тендер шалгаруулалтын тухайд тендер хүлээн авах эцсийн хугацааг 30 буюу түүнээс дээш хоногоор тогтооно.
- 24.4.Тендер бэлтгэх зорилгоор ажлын талбай үзэх шаардлагатай бол түүнд шаардагдах хугацааг оруулан тооцно.
- 24.5.Тендерт оролцогч өөрийн тендерийн хүчинтэй байх хугацааг 30-аас доошгүй хоног байхаар тендерт заана.
[/Энэ хэсгийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)
[/Энэ хэсгийг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)
[/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

25 дугаар зүйл.Тендер ирүүлэх

- 25.1.Тендерийг тендерийн баримт бичигт товлосон хугацаанд, дурдсан хаягаар, заасан хэлбэрээр ирүүлэх бөгөөд тендерт оролцогч энэ хугацаанд тендерт нэмэлт, өөрчлөлт оруулах, татгалзах саналаа ирүүлж болно.
- 25.2.Энэ хуулийн 21.5.6-д заасан хугацаанаас хожимдож ирсэн, эсхүл тендерийн баримт бичигт зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн тендерийг хүлээж авахгүй бөгөөд хаягаар нь буцаана.
- 25.3.Тендерийн агуулга, үнэлгээний явц болон тендерт оролцогчийн чадавхийг үнэлэхтэй холбогдсон энэ хуулийн 26 дугаар зүйлд зааснаас бусад мэдээллийг гэрээ байгуултал нууцална.

26 дугаар зүйл.Тендер нээх

- 26.1.Захиалагч хүлээн авсан бүх тендерийг тендерийн баримт бичигт заасан газар, товлосон хугацаанд нийтийн өмнө нээх бөгөөд тендер нээх хугацааг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 1 цагийн дотор байхаар товлон.
- 26.2.Тендер нээхэд тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд оролцох эрхтэй.
- 26.3.Тендер нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, тендерийг хувилбарт саналтайгаар ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд хувилбарт саналын үнэ, мөн тендерт тусгасан үнийн хөнгөлөлт, тендерийн баталгаа ирүүлсэн эсэх, оролцогч өөрийн тендерийг өөрчилсөн, эсхүл татгалзсан тухай мэдээллийг захиалагч зарлаж, тэмдэглэл үйлдэнэ.
- 26.4.Энэ хуулийн 26.2-т заасан этгээд, захиалагч байгууллагын төлөөлөгч энэ зүйлийн 26.3-т заасан тэмдэглэлд гарын үсэг зурна.
- 26.5.Энэ хуулийн 26.3-т заасан тэмдэглэлийг сонирхсон этгээдэд танилцуулна.
- 26.6.Тендер нээх үед энэ хуулийн 26.3-26.5-д зааснаас бусад үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргахыг хориглоно.
- 26.7.Тендер нээх үед зарлагдаагүй, тэмдэглэлд заагаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийн үнийг үнэлгээ хийхэд тооцохгүй.
- 26.8.Захиалагч тендер нээсний дараа тендерийн агуулга, үнийн талаар тендерт оролцогчтой санал солилцохыг хориглоно.
- 26.9.Тендерийн агуулга, үнийг өөрчлөхөөс бусад асуудлаар тайлбар тодруулгыг бичгээр ирүүлэхийг захиалагч тендерт оролцогчоос шаардаж болно.
- 26.10.Захиалагч энэ хуулийн 26.9-д зааснаар нэмж ирүүлсэн тайлбар, тодруулгыг бүртгэж хадгална.

27 дугаар зүйл.Тендерийг хянан үзэх

- 27.1.Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараахь шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ:
- 27.1.1.энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхийн шаардлага;
- 27.1.2.техникийн тодорхойлолт;
- 27.1.3.тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага.
- 27.2.Энэ хуулийн 27.1-д заасан шаардлагыг хангасан эсэхийг хянахдаа дараахь шалгуур үзүүлэлтийг удирдлага болгоно:
- 27.2.1.бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд үзүүлэх сөрөг нөлөө;
- 27.2.2.захиалагчийн санал болгосон гэрээний нөхцөлд хуульд үл нийцэх хязгаарлалт оруулсан эсэх;
- 27.2.3.энэ хуулийн 27.2.1, 27.2.2-т заасныг хүлээн зөвшөөрснөөр шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх эсэх.
- 27.3.Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.
- 27.4.Энэ хуулийн 27.3-т зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж захиалагч уг тендерээс татгалзана.

28 дугаар зүйл.Тендерийг үнэлэх

28.1.Нэг үе шаттай тендер шалгаруулалтын үед энэ хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хянаж, шаардлагад нийцсэн гэж үзсэн бүх тендерт үнэлгээ хийнэ.

28.2.Тендерийн үнэлгээг тендер хүчинтэй байх хугацаанд багтааж аль болох богино хугацаанд хийнэ.

28.3.Шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна.

28.4.Захиалагч худалдан авах зөвлөхийн үйлчилгээнээс бусад бараа, ажил, үйлчилгээний онцлогийг харгалзан өөрийн эдийн засгийн үр ашигт нөлөөлөх дор дурдсан хүчин зүйлсээс аль тохирохыг сонгож, мөнгөөр илэрхийлэн тендерийн үнэ дээр нэмж харгалзан тооцож болно:

28.4.1.ажил, үйлчилгээ дуусгах, бараа хүргэх хугацаа;

28.4.2.урсгал зардал, эсхүл зардал болон үр ашгийн тооцоо;

28.4.3.борлуулалтын дараах үйлчилгээ, техникийн туслалцаа;

28.4.4.сэлбэг хэрэгсэл нийлүүлэх болон үнийн талаар гаргах баталгаа;

28.4.5.бараа, ажил, үйлчилгээний чанар, техникийн үзүүлэлт;

28.4.6.энэ хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт.

28.5.Энэ хуулийн 28.4-т заасан нэмж тооцох үнэлгээ нь зөвхөн тендерүүдийг харьцуулах зорилготой бөгөөд тендерийн үнийг өөрчлөх үндэслэл болохгүй.

28.6.Тендерийн баримт бичигт өөрөөр заагаагүй бол тендерийн үнэд татвар, даатгал, тээвэрлэлтийн болон гэрээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах бусад бүх зардлыг багтааж тооцох бөгөөд эдгээр зардлыг тендерийн үнэд тусгайлан тооцоогүй бол захиалагч тухайн зардлыг тендерийн үнэд багтсан гэж үзнэ.

28.7.Шаардлагад нийцсэн тендерийг дараахь байдлаар харьцуулж үнэлнэ:

28.7.1.тендерийн үнэд арифметик алдаа болон орхигдуулсан жижиг хэмжээний зөрүүг залруулах, үнийн хөнгөлөлтийг харгалзан тендерийн үнийг бууруулах, захиалагч энэ хуульд заасныг үндэслэн үнэлгээний бусад шалгуур үзүүлэлтийг сонгосон бол тэдгээрт харгалзах саналуудыг мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэ дээр харгалзан тооцож тендерийн харьцуулах үнийг тодорхойлно;

28.7.2.давуу эрх олгохоор тендерийн баримт бичигт заасан бол давуу эрх эдлэх этгээдийн ирүүлсэн тендерийн харьцуулах үнэд энэ хуулийн 10.2-т заасан хувь хэмжээг тооцно;

28.7.3.энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж, энэ хуульд заасны дагуу үнэлэгдсэн тендерүүдийг бага харьцуулах үнэтэйгээс их харьцуулах үнэтэй рүү нь эрэмбэлж, хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгоно;

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

28.7.4.хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер гэж үзнэ.

28.7.5.эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад чанар ба үнэлгээний харьцуулалтаар өндөр оноо бүхий тендерийг "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер гэж үзнэ.

[/Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

28.8.Зөвлөх үйлчилгээний саналыг үнэлэхэд энэ хуулийн 37, 38, 39 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

28.9.Захиалагч энэ хуулийн 28.4-т дурдсан шалгуур үзүүлэлтээс сонгож хэрэглэх бол тэдгээрийг мөнгөөр илэрхийлж үнэлгээнд харгалзах нөхцөл, аргачлалыг энэ хуульд нийцүүлэн тогтоож тендерийн баримт бичигт тусгана.

28.10.Энэ хуулийн 28.4-т заасан шалгуур үзүүлэлтэд тендер оролцогчийн чадавхийн үзүүлэлтүүдийг хамааруулахгүй бөгөөд энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасны дагуу захиалагчийн тогтоосон доод шаардлагыг давуулан хангаж байгаа нь түүний тендерийг шалгаруулах үндэслэл болохгүй.

28.11.Захиалагч шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлж «хамгийн сайн» үнэлэгдсэн тендерийг шалгаруулахад шалгуур үзүүлэлтүүдийг тендерийн баримт бичигт заасан журмын дагуу ашиглана.

28.12.Тендерийн үнэлгээнд гадаад валют ашиглах бол энэ талаар тендерийн баримт бичигт заана.

28.13.Тендерийн баримт бичигт зааснаас өөр гадаад валютыг төлбөр тооцоонд хэрэглэх бол түүнийг хөрвүүлэх ханшийг тендер зарласан өдөр Монголбанкнаас зарласан ханшаар тооцно.

28.14.Нээлттэй тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай явуулах үед тендерийн үнэлгээг дараахь байдлаар хийнэ:

28.14.1.техникийн саналыг энэ хуулийн 27 дугаар зүйлийн дагуу шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх;

28.14.2.энэ хуулийн 27.1-д заасан шаардлагыг хангасан техникийн санал тус бүрийн талаар тухайн оролцогчтой захиалагчийн хэрэгцээг илүү хангасан жишиг техникийн тодорхойлолт бэлтгэх зорилгоор санал солилцох;

28.14.3.санал солилцсоны дараа захиалагч жишиг техникийн тодорхойлолт гаргах;

28.14.4.тендер оролцогч энэ хуулийн 28.14.3-т заасан жишиг техникийн тодорхойлолтод нийцүүлэн өөрийн техникийн саналыг дахин хянаж, өөрчлөн санхүүгийн саналын хамт ирүүлэх;

28.14.5.захиалагч санхүүгийн саналыг товлосон хугацаанд, нийтийн өмнө нээх;

28.14.6.санхүүгийн саналыг энэ хуулийн 28.2-28.7-г баримтлан үнэлж, гэрээ байгуулах эрхийг «хамгийн сайн» гэж үнэлэгдсэн тендерт оролцогчид олгох.

28.15.Тендерт оролцогч нь энэ хуулийн 28.14.3-т зааснаар захиалагчаас тогтоосон жишиг техникийн тодорхойлолтын дагуу өөрийн тендерт өөрчлөлт оруулах боломжгүй гэж үзвэл захиалагч уг тендерээс татгалзах эрхтэй.

28.16.Тендер үнэлэх аргачлал, зааврыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийг 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

29 дүгээр зүйл.Гэрээ байгуулах эрх олгох

29.1.Захиалагч тендер нээснээс хойш ажлын 15 өдрийн дотор энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрт шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ.

[/Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

29.2.Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй өдрийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.

[/Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

29.3.«Хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ байгуулахаас татгалзсан, эсхүл энэ хуулийн 20.7.2-т заасан нөхцөл үүссэн бол түүнд олгосон гэрээ байгуулах эрхийг захиалагч хүчингүй болгож, удаахь “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд ийм оролцогч байхгүй бол 30.4-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.

29.4.Захиалагчаас үл хамаарах шалтгаанаар тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулах боломжгүй болсон бол захиалагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гарган, зөвшөөрөл авсны үндсэн дээр уг хугацааг нэг удаа 15 хоногоор сунгаж болно.

[/Энэ хэсгийг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

29.5.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 29.4-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянаж, захиалагчийн ирүүлсэн баримт бичиг, мэдээлэл болон бусад тодруулгад үндэслэн шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

29.6.Урьдчилсан худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтад шалгарсан тендерт оролцогчтой тухайн зээл, тусламжийн олон улсын гэрээ, улсын төсвийн санхүүжилт батлагдаагүй тохиолдолд гэрээ байгуулахыг хориглоно.

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

29.7.Энэ хуулийн 29.4-т заасан тендерийн хүчинтэй байх хугацаа өнгөрснөөс хойш энэ хуулийн 29.6-д заасан зээл, тусламжийн олон улсын гэрээ, улсын төсвийн санхүүжилт батлагдсан тохиолдолд тухайн тендер шалгаруулалтыг хүчинтэйд тооцно.

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

30 дугаар зүйл.Бүх тендерээс татгалзах

30.1.Дараахь тохиолдолд захиалагч бүх тендерээс татгалзана:

30.1.1.шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй;

30.1.2.тендер шалгаруулалтад үнийг урьдчилан тохиролцож оролцсон, өрсөлдөгчөө тендер шалгаруулалтын бодит нөхцөлөөс төөрөгдүүлсэн, тэдэнд дарамт, шахалт үзүүлсэн нь шүүх, эрх бүхий байгууллагаас тогтоогдсон бол;

30.1.3.шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн;

30.1.4.энэ хуулийн 30.2-т заасан хэлэлцээ амжилтгүй болсон.

30.2.Шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс хэтэрсэн тохиолдолд захиалагч 5 хүртэлх хувиар хэтэрсэн үнэтэй тендер ирүүлсэн тендерт оролцогчтой гэрээний үнийг төсөвт өртөгт багтаах зорилгоор хэлэлцээ хийх бөгөөд ийнхүү хэлэлцээ хийхдээ захиалагч тендерт оролцогчийн санал болгосон үнийг үндэслэлгүйгээр бууруулахыг шаардахыг хориглоно.

30.3.Энэ хуулийн 30.1-д заасны дагуу бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч тендерт оролцогчийн өмнө хариуцлага хүлээхгүй.

30.4. Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

30.4.1.тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах;

30.4.2.энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах;

30.4.3.энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ОНЦГОЙ ЖУРАМ

31 дүгээр зүйл.Тендер шалгаруулалтын онцгой журам хэрэглэх

31.1.Тендер шалгаруулалтыг онцгой журмаар явуулахдаа дараахь аргыг хэрэглэнэ:

31.1.1.хязгаарлагдмал тендер шалгаруулалт;

31.1.2.харьцуулалт;

31.1.3.гэрээ шууд байгуулах.

31.2.Тендер шалгаруулалтыг онцгой журмаар явуулахтай холбогдсон энэ хуулийн 32-34 дүгээр зүйлээр зохицуулаагүй харилцааг энэ хуулийн 2 дугаар бүлгийн холбогдох зүйл, хэсэг, заалтаар зохицуулна.

32 дугаар зүйл.Хязгаарлагдмал тендер шалгаруулалт

32.1.Хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргыг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

32.1.1.мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага, техник, технологи шаардсан нарийн төвөгтэй бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх чадвартай этгээдийн тоо хязгаарлагдмал;

32.1.2.энэ хуулийн 30.4.2-т заасан тохиолдолд.

32.2.Хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулахдаа захиалагч энэ хуулийн 52.1.12-т заасан цахим хуудсанд тендерийн урилгыг нийтэлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана.

[/Энэ хэсгийг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

32.3.Тендерийн урилга энэ хуулийн 21.5-д заасан мэдээллийг агуулна.

32.4.Тендерийн баримт бичгийг сонирхсон этгээдэд энэ хуулийн 22.2-т заасны дагуу саадгүй олгоно.

32.5.Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг тендерийн урилга тараасан өдрөөс хойш 15 буюу түүнээс дээш хоногоор тогтооно.

33 дугаар зүйл.Харьцуулалтын арга

33.1.Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно.

33.2.Харьцуулалтын аргыг дараахь байдлаар хэрэглэнэ:

33.2.1.үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх;

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

33.2.2.техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох.

33.3.Энэ хуулийн 33.2.1-д заасан үнийн санал ирүүлэх хугацааг урилга зарласан өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор тогтооно.

[/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

33.4.Харьцуулалт амжилтгүй болсноос гэрээ байгуулах эрх олгоогүй бол гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэж болно.

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

34 дүгээр зүйл.Гэрээ шууд байгуулах арга

34.1.Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараахь нөхцөлд хэрэглэж болно:

34.1.1.энэ хуулийн 30.4.3, 36.18-д заасан тохиолдолд;

34.1.2.оюуны өмчийн эрх, соёлын биет өвийг хамгаалах шаардлагаар гэрээг зөвхөн нэг этгээдтэй байгуулах боломжтой бөгөөд түүнийг орлох этгээд байхгүй бол;

34.1.3.нэмэлт нийлүүлэлт нь анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол;

34.1.4.нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувиас хэтрээгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол;

[/Энэ заалт ад 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

34.1.5.гамшгийн онц нөхцөл байдал зарласан, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол;

34.1.6.улсын төсвийн хөрөнгөөр барьж байгуулах авто зам, эрчим хүчний төслийн хөрөнгө оруулалтын хэмжээ нь тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг дотоодын нийт аж ахуйн нэгжүүдийн хүчин чадалтай тэнцүү буюу түүнээс хэтэрсэн тохиолдолд Засгийн газар жишиг үнийг үндэслэн гүйцэтгэгчдийг шууд сонгох шаардлагатай гэж үзсэн бол;

[/Энэ заалтыг 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар нэмсэн, 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

34.1.7.хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зарим онцгой эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах шаардлагатай гэж үзсэн бол;

[/Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

34.1.8.хорих анги дахь үйлдвэрийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах бол;

[/Энэ заалтыг 2017 оны 6 дугаар сарын 9-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

34.1.9.яаралтай дархлаажуулалтад шаардагдах, олон улсын лавлагаа лабораториор баталгаажсан вакциныг үйлдвэрлэгчээс нь шууд худалдан авах.

[/Энэ заалтыг 2017 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

34.1.10.хүнсний аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагаар чанарын шаардлага хангасан тарианы үрийг үйлдвэрлэгчээс авах бол.

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

34.1.11.энэ хуулийн 10¹.2-т заасан дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтад орсон бараа, бүтээгдэхүүнийг Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5.1-д заасан жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч үйлдвэрлэсэн бол.

[/Энэ заалтыг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

34.2.Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.

34.3.Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

34.4.Энэ хуулийн 34.1-д заасан гүйцэтгэгчдийг нь шууд сонгох төслийн жагсаалтыг Засгийн газар батална.

[/Энэ хэсгийг 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар нэмсэн, 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ ЖУРАМ

35 дугаар зүйл.Зөвлөх сонгох

35.1.Зөвлөх үйлчилгээг хуулийн этгээд, хувь хүн гүйцэтгэж болно.

35.2.Тухайн зөвлөх үйлчилгээ нь олон салбарын мэдлэг, нарийн мэргэжлийн боловсон хүчин шаардахаар бол хуулийн этгээдийг сонгоно.

35.3.Тухайн зөвлөх үйлчилгээг шаардлагатай мэргэжил, туршлага бүхий зөвлөх хувь хүн илүү сайн гүйцэтгэж чадахаар бол түүнийг сонгоно.

36 дугаар зүйл.Зөвлөх сонгох нийтлэг журам

36.1.Захиалагч шаардагдаж байгаа үйлчилгээний зорилт, хүрэх үр дүн болон бусад шаардлагатай мэдээллийг агуулсан ажлын даалгавар бэлтгэнэ.

36.2.Ажлын даалгавар нь түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хамт тухайн зөвлөхтэй байгуулах гэрээний салшгүй хэсэг болно.

36.3.Захиалагч шаардагдаж байгаа үйлчилгээний төсөвт өртгийг тооцохдоо боловсон хүчний мэргэжлийн чиглэл, түвшин, зөвлөхийн ажлын талбайд болон төв байранд ажиллах хугацаа, бичиг хэргийн болон тухайн үйлчилгээнд шаардлагатай бусад зардалд үндэслэсэн байна.

36.4.Захиалагч ажлын даалгавар бэлтгэж, төсөвт өртгийг тооцоолж гаргасны дараа зөвлөхийн жагсаалтад орох саналаа ирүүлэхийг хүссэн урилгыг өдөр тутмын болон бусад хэвлэлд нийтэлнэ.

36.5.Дэлгэрэнгүй жагсаалтад дор дурдсан этгээдийг оруулж болно:

36.5.1.энэ хуулийн 36.4-т заасан урилгын хариуд санал ирүүлсэн зөвлөх;

36.5.2.Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа дотоодын болон олон улсын зөвлөх;

36.5.3.энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан бүртгэлд бүртгэгдсэн зөвлөх;

36.5.4.мэргэжлийн холбоо, олон улсын санхүүгийн болон бусад байгууллагын зөвлөх.

36.6.Дэлгэрэнгүй жагсаалтад санал ирүүлэх хугацааг ажлын 7-оос доошгүй өдрөөр тогтооно.

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

36.7.Дэлгэрэнгүй жагсаалтад хамрагдсан зөвлөхүүдээс энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлага болон захиалагчаас тогтоосон чадавхийн үзүүлэлтийг хангасан 3 ба түүнээс дээш зөвлөхийг захиалагч сонгож, хураангуй жагсаалт гаргана.

36.8.Захиалагч саналын урилга болон ажлын даалгаврыг хураангуй жагсаалтад нэр нь орсон зөвлөхөд хүргүүлнэ.

36.9.Саналын урилгад дараахь зүйлийг тусгана:

36.9.1.тухайн үйлчилгээний болон санхүүжилтийн тодорхойлолт;

36.9.2.ажлын даалгавар;

36.9.3.энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтэд үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхийн шаардлага, 28.11-д заасны дагуу захиалагчийн тогтоосон үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлал;

36.9.4.уригдсан зөвлөх хуулийн этгээд, хувь хүний нэр;

36.9.5.гэрээний төсөл;

36.9.6.санал ирүүлэхэд баримтлах зааварчилгаа;

36.9.7.сонгосон үнэлгээний арга.

36.10.Санал ирүүлэх хугацаа нь 60 хоногоос дээшгүй байх боловч хуулийн этгээдийн хувьд 30-аас дээш, хувь хүний хувьд 7-оос дээш хоногоор тогтоож саналын урилгад тодорхой заана.

36.11.Зөвлөх техникийн болон санхүүгийн саналыг тус тусад нь бэлтгэнэ.

36.12.Техникийн саналд зөвлөхийн мэргэжлийн чадвар, туршлага, хуулийн этгээдийн хувьд голлох мэргэжилтэн, үйл ажиллагааны арга барилтай холбоотой мэдээллийг тусгана.

36.13.Техникийн саналд заасан нөхцөлөөр гэрээ хэрэгжүүлэх үнийг санхүүгийн саналд тусгана.

36.14.Техникийн саналыг үнэлсний дараа санхүүгийн саналыг үнэлнэ.

36.15.Санхүүгийн болон техникийн саналыг нэгэн зэрэг ирүүлэх бөгөөд саналын урилгад тусгайлан заасан бол тус тусад нь дугуйлан битүүмжилнэ.

36.16.Захиалагч энэ хуулийн 37-39 дүгээр зүйлийн дагуу техникийн болон санхүүгийн саналыг үнэлж, сонгосон зөвлөхтэй хийсэн хэлэлцээр амжилттай болсон тохиолдолд түүнд энэ хуулийн 29 дүгээр зүйлийн дагуу гэрээ байгуулах эрх олгоно.

36.17.Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт амжилтгүй болсон тохиолдолд зөвлөхийн хураангуй жагсаалтыг дахин гаргаж, санал ирүүлэх хугацааг ажлын 5 ба түүнээс дээш өдрөөр тогтооно.

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

36.18.Энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан зөвлөх сонгох тендер шалгаруулалт хоёр удаа амжилтгүй болсон тохиолдолд шууд гэрээ байгуулж болно.

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

37 дугаар зүйл. Зөвлөх сонгох үнэлгээний арга

- 37.1. Захиалагч зөвлөх сонгох үнэлгээний аргыг саналын урилга илгээхээс өмнө тодорхойлно.
- 37.2. Зөвлөх сонгох үнэлгээний арга нь чадварын, чанарын болон хосолмол үнэлгээний гэсэн хэлбэртэй байна.
- 37.3. Зөвлөх хувь хүнийг сонгоход чадварын үнэлгээний аргыг хэрэглэх бөгөөд үүнд түүний мэдлэг, туршлага, мэргэшлийн түвшин, мэргэжлийн бусад ур чадварыг үндэслэл болгоно.
- 37.4. Зөвлөх хуулийн этгээдийг сонгоход чанарын, эсхүл хосолмол үнэлгээний аргыг хэрэглэнэ.
- 37.5. Мэргэжлийн туршлага, техникийн чадварын хувьд төвөгтэй, эсхүл цогцолбор буюу өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой хэд хэдэн үйлчилгээг нэгэн зэрэг гүйцэтгүүлэх гэрээний үед чанарын үнэлгээний аргыг хэрэглэж зөвлөх хуулийн этгээдийг сонгоно.
- 37.6. Энэ хуулийн 37.3, 37.5-д зааснаас бусад тохиолдолд хосолмол үнэлгээний аргыг хэрэглэнэ.

38 дугаар зүйл. Зөвлөх сонгох чанарын үнэлгээний арга

- 38.1. Санал болгож байгаа зөвлөх үйлчилгээний үйл ажиллагааны арга зүй, ажлын хуваарь, боловсон хүчний туршлага, чадвар, үйлчилгээний болон техник хэрэгслийн чанарыг харгалзан саналуудад шинжилгээ хийж харьцуулна.
- 38.2. Энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг үндэслэн техникийн саналд оноо өгнө.
- 38.3. Захиалагч техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан зөвлөхийн санхүүгийн саналыг нээж, тухайн зөвлөхтэй санхүүгийн болон бусад нөхцөлийг харилцан тохиролцох хэлэлцээ хийнэ.
- 38.4. Энэ хуулийн 38.3-т заасан хэлэлцээ хийхдээ захиалагч зөвлөхийн санал болгосон үнийг үндэслэлгүйгээр бууруулахыг шаардаж болохгүй.
- 38.5. Зөвлөх, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд хэлэлцээ хийхэд шаардагдах баримт бичиг, тооцоо, судалгаа, шаардлагатай бусад мэдээлэл, нотолгоогоор захиалагчийг хангах үүрэгтэй.
- 38.6. Талууд санхүүгийн, эсхүл гэрээний бусад нөхцөлөөр тохиролцоонд хүрээгүй бол сонгосон зөвлөхтэй хийж байгаа хэлэлцээг зогсоож, захиалагч удаахь өндөр оноо авсан зөвлөхийн санхүүгийн саналыг нээн, түүнтэй хэлэлцээ хийнэ.

39 дүгээр зүйл. Зөвлөх сонгох хосолмол үнэлгээний арга

- 39.1. Захиалагч хосолмол үнэлгээний аргыг хэрэглэх тохиолдолд техникийн саналын авбал зохих доод оноог саналын урилгад заана.
- 39.2. Техникийн саналыг энэ хуулийн 14-16-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд үндэслэн оноо өгч үнэлнэ.
- 39.3. Техникийн саналд авбал зохих доод буюу түүнээс дээш оноо авсан зөвлөхүүдэд санхүүгийн саналыг нээх хугацааг мэдэгдэж, доод оноо аваагүй бусад зөвлөхийн санхүүгийн саналыг нээлгүй буцаана.
- 39.4. Техникийн саналд авбал зохих доод буюу түүнээс дээш оноо авсан зөвлөхийн санхүүгийн саналыг тогтоосон хугацаанд нийтийн өмнө нээж тэмдэглэл үйлдэнэ.
- 39.5. Санхүүгийн саналыг нээхэд зөвлөх, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.
- 39.6. Нээсэн бүх санхүүгийн саналыг энэ хуулийн 36.9.3-т заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, оноо өгнө.
[/Энэ хэсэгт 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)
- 39.7. Техникийн болон санхүүгийн саналын оноог саналын урилгад тусгасан хувийн жинг харгалзан хооронд нь нэмж чанар үнийн үнэлгээний нийт оноог гаргана.
- 39.8. Захиалагч хамгийн өндөр оноо авсан зөвлөхтэй хэлэлцээ хийнэ.
- 39.9. Хэлэлцээгээр шаардлагатай бол хүн-сар, хүн-өдрийн тоо, ажлын талбайд болон төв байранд зөвлөхийн ажиллах хугацаа, бичиг хэргийн зэрэг тухайн үйлчилгээнд тавигдах шаардлагыг өөрчилж болно.
- 39.10. Хэлэлцээгээр хүн-сар, хүн-өдрийн өртөг зэрэг санал болгосон нэгж үнийг өөрчилж үл болно.
- 39.11. Талууд санхүүгийн бус нөхцөлөөр тохиролцоонд хүрээгүй бол захиалагч сонгосон зөвлөхтэй хийж байгаа хэлэлцээг зогсоож, удаахь оноо авсан зөвлөхтэй хэлэлцээ хийнэ.
- 39.12. Аудит, инженерийн ердийн тооцоо, зураг төсөл зэрэг хэвшсэн үйл ажиллагаатай, гэрээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.3-т заасан босго үнээс хэтрээгүй зөвлөх үйлчилгээнд хосолмол үнэлгээний аргын хялбаршуулсан хэлбэр болох бага үнийн аргыг хэрэглэж болно.
- 39.13. Бага үнийн арга хэрэглэхдээ энэ хуулийн 39.2-39.4-д заасны дагуу техникийн саналыг үнэлж, санхүүгийн саналыг нээнэ.
- 39.14. Хамгийн бага үнийн санал ирүүлсэн зөвлөхтэй энэ хуулийн 39.9-39.11-д заасны дагуу хэлэлцээ хийнэ.
- 39.15. Бага үнийн аргыг хэрэглэх тохиолдолд санал ирүүлэх хугацааг ажлын 5 ба түүнээс дээш өдрөөр тогтооно.
[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

ТАВДУГААР БҮЛЭГ

БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

40 дүгээр зүйл. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ

40.1. Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ /цаашид "худалдан авах гэрээ" гэх/-тэй холбоотой харилцааг энэ хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хуулиар зохицуулна.

40.2. «Хамгийн сайн» үнэлэгдсэн тендер болон тендерийн баримт бичигт захиалагчийн тодорхойлсон худалдааны болон техникийн шаардлага нь худалдан авах гэрээний үндсэн нөхцөл болно.

40.3. Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараахь нөхцөлийг заавал тусгана:

40.3.1. гэрээний үнэ;

40.3.2. төлбөр хийх нөхцөл, хэлбэр;

40.3.3. урьдчилгаа төлбөр хийх бол урьдчилгаа төлбөрийн баталгааны дүн, хэлбэр;

40.3.4. захиалагчийн хяналт болон бусад нөхцөл;

40.3.5. гүйцэтгэлийн баталгаа шаардах бол түүний дүн, хэлбэр;

40.3.6. худалдааны нөхцөлүүд;

40.3.7. бараа нийлүүлэх, ажил, үйлчилгээ гүйцэтгэх хуваарь;

~~40.3.8. гэрээний үнэд тохируулга хийх бол тохируулга хийх нөхцөл, аргачлал.~~

[/Энэ хэсгийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

40.4. Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлсний үнэд захиалагч дараахь тохиолдолд тохируулга хийхээр гэрээнд тусгаж болно:

40.4.1. хоёр жилээс дээш хугацаанд хэрэгжих гэрээний явцад хэрэглээний үнийн индекс өөрчлөгдсөн;

40.4.2. суурь үнэ огцом өөрчлөгдсөн.

40.5. Худалдан авах ажиллагаанд мөрдөх гэрээний стандарт нөхцөлийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

40.6. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих ажил гүйцэтгэх төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотойгоор төсөвт өртгийг хуулиар нэмэгдүүлэн баталсан бол захиалагч магадлалын дүгнэлтэд үндэслэн тухайн ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үнэ, ажлын тоо хэмжээг нэмэгдүүлэн баталсан төсөвт өртөгт багтаан нэг удаа өөрчилж болно.

[/Энэ хэсгийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

41 дүгээр зүйл. Худалдан авах гэрээнд нэмэлт, өөрчлөлт хийхийг хориглох

41.1. Худалдан авах гэрээнд дараахь өөрчлөлт хийхийг хориглоно:

41.1.1. захиалагч урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэний улмаас гэрээнд зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийхээс бусад тохиолдолд тендерийн агуулгатай холбоотой гэрээний нөхцөлүүдийг өөрчлөх;

41.1.2. энэ хуулийн 40.4, 40.6-д зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх.

[/Энэ заалт ад 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

41.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

42 дугаар зүйл. Хүчин төгөлдөр бус гэрээ

42.1. Худалдан авах гэрээг дараахь тохиолдолд хүчин төгөлдөр бус гэж үзнэ:

42.1.1. захиалагч гэрээ байгуулахдаа энэ хуулийн 53 дугаар зүйлд заасан зөвшөөрөл аваагүй;

[/Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

42.1.2. захиалагч энэ хуулийн 27, 28, 29 дүгээр зүйлд заасан журмыг зөрчиж гэрээ байгуулсан;

42.1.3. энэ хуульд заасан худалдан авах ажиллагааны журмыг хэрэгжүүлэхдээ гаргасан зөрчил нь тендер шалгаруулалтын эцсийн дүнд илт нөлөөлсөн.

43 дугаар зүйл. Гүйцэтгэлийн баталгаа, түүний хэмжээ, гүйцэтгэлийн баталгаа гаргах

43.1. Захиалагч «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчоос гэрээ байгуулахаас өмнө гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг шаардаж болно.

43.2.Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувиар тогтоож тендерийн баримт бичигт тусгана.

[/Энэ заал т ад 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

43.3.Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээ дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээлцэх хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.

43.4.Захиалагч дор дурдсан нөхцөлд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана:

43.4.1. 150 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажил худалдан авах гэрээ байгуулах;

43.4.2. 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах;

43.4.3.хоёр жилээс дээш хугацаагаар үргэлжлэх худалдан авах гэрээ байгуулах.

43.5.Худалдан авах гэрээний гүйцэтгэл хоёр жилээс дээш хугацаагаар үргэлжлэх бол захиалагч гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын хувьтай тэнцүү хувиар гүйцэтгэлийн баталгааны дүнг бууруулж болно.

43.6.Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно.

[/Энэ хэсэг т 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмэл т оруулсан./](#)

43.7.Гүйцэтгэгч энэ хуулийн 43.6-д заасан үүргээ банкны баталгаа, даатгагчийн баталгаа, Засгийн газрын бондоор баталгаажуулж болох бөгөөд ийнхүү баталгаажуулсан тохиолдолд захиалагч барьцаалсан мөнгийг уг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр урьдчилан олгоно.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсэг т 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмэл т оруулсан./](#)

43.8.Төсвийн жил дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааны хугацаа дуусахаас өмнө захиалагчид гүйцэтгэлийн баталгааг шинэчлэн хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

43.9.Гүйцэтгэгч энэ хуулийн 43.8-д заасан гүйцэтгэлийн баталгааг шинэчлэн хүргүүлэх үүргээ гүйцэтгээгүй бол түүнийг гэрээний үүргээ зөрчсөнд тооцож, гүйцэтгэлийн баталгааг орлого болгоно.

[/Энэ хэсгийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

44 дүгээр зүйл.Урьдчилгаа төлбөр, түүний баталгаа

44.1.Захиалагч ажлын бэлтгэл хангахад зориулан гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлж болно.

44.2.Захиалагч урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцүү хэмжээтэй гүйцэтгэгчийн ирүүлсэн энэ хуулийн 20.2-т заасан баталгааг үндэслэн урьдчилгаа төлбөр төлнө.

44.3.Урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнд гүйцэтгэлийн баталгааны дүнг оруулан тооцож болно.

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

44.4.Тендерийн баримт бичигт заагаагүй тохиолдолд захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА

45 дугаар зүйл.Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулах

45.1.Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.

45.2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад дор дурдсан этгээд захиалагч байна:

45.2.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, төрийн захиргааны төв болон Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллага, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллага, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нь өөрийн хэрэгцээнд худалдан авах бүх бараа, ажил, үйлчилгээний хувьд;

[/Энэ заал т ад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

45.2.2.аймаг, нийслэлийн Засаг дарга нь тухайн орон нутагт худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд.

[/Энэ заал т ад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

[/Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

45.3.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг дарга захиалагч байна.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

45.4.Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 45.2, 45.3-т зааснаас бусад болон энэ хуулийн 45.5-д заасан улсын болон бүс нутгийн чанартай бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч байна.

[/Энэ хэсгийг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

45.5.Тухайн төсвийн жилд Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хэрэгжүүлэх улсын болон бүс нутгийн чанартай төсөл, арга хэмжээний жагсаалтыг улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 5 өдрийн дотор Засгийн газар батална.

[/Энэ хэсгийг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

45.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь шаардлагатай гэж үзвэл сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт энэ хуулийн 45.2.2-т заасан эрхээ шилжүүлж болно.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

45.7.Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, хил хамгаалах, онцгой байдлын байгууллага, цагдаа, дотоодын цэрэг, хорих байгууллагын тусгай хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээг тухайн салбарын төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гүйцэтгүүлэх, хорих байгууллагын өөрийн хэрэгцээний ажлыг холбогдох хуулийн дагуу гүйцэтгүүлэх нь үр ашигтай гэж захиалагч үзсэн, түүнчлэн хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газрын худалдан авах ажиллагааг зохион байгуулахад төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан зөвшөөрлийн үндсэн дээр нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхгүй байж болно.

[/Энэ хэсгийг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

46 дугаар зүйл.Захиалагчийн эрх, үүрэг

46.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараахь эрх, үүрэгтэй байна:

46.1.1.энэ хуульд заасны дагуу үнэлгээний хороо байгуулах;

46.1.2.үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах;

46.1.3.үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах;

46.1.4.худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;

46.1.5.энэ хуулийн 7.6-д зааснаас бусад бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх;

46.1.6.гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах;

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

46.1.7.хууль, гэрээнд зааснаас бусад тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулахгүй байх;

46.1.8.барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх;

46.1.9.гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний баталгаат хугацааны туршид заавал байрлуулахыг шаардах.

[/Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

46.2.Энэ хуулийн 4.1.1-д заасан захиалагчийг төлөөлж төсвийн ерөнхий менежер, 4.1.2-т заасан захиалагчийг төлөөлж гүйцэтгэх захирал энэ хуулийн

46.1-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

46.3.Энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий этгээд энэ хуулиар өөрт олгогдсон эрхийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж болох боловч ийнхүү эрхээ шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

46.4.Захиалагч тухайн худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар зөвхөн албан бичгээр харилцана.

47 дугаар зүйл. Үнэлгээний хороо

47.1.Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна.

47.2.Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна:

47.2.1.техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх;

47.2.2.тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх. Уг шийдвэрийг энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан үндэслэлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

[/Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

47.3.Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орсон албан тушаалтан дараахь шаардлагыг хангасан байвал зохино:

47.3.1.худалдан авах ажиллагааны чиглэлээр, эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн байх;

47.3.2.тендерт оролцогч болон түүнийг төлөөлөх этгээдийн эцэг, эх, хадам эцэг, эх, эхнэр, нөхөр, ах, эгч, дүү, хүүхэд биш байх;

47.3.3.сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчтой хөдөлмөрийн гэрээний харилцаанд ороогүй байх;

47.3.4.энэ хуулийн 50.1-д заасан төрийн албан хаагчийн үүргийг сүүлийн 1 жилийн хугацаанд зөрчөөгүй.

47.4.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

47.5.Энэ хуулийн 47.4 дэх хэсэгт заасан үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилох, тэднийг төрийн зардлаар мэргэшүүлж сургах болон ажиллах журмыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

47.6.Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна.

[/Энэ хэсэгт 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

47.7.Үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр /цаашид “үнэлгээний дүгнэлт” гэх/ нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд хорооны гишүүдийн олонхи дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох бүх мэдээллийг агуулсан байна.

47.8.Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна.

47.9.Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

48 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааг төлөвлөх

48.1.Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

48.2.Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн төсвийн хүрээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг нэгтгэн гаргаж, төсвийн төслийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

48.3.Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 45.4-т заасан худалдан

авах бараа, ажил, үйлчилгээний захиалгыг төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ.

48.4.Төсвийн ерөнхийлөн захирагч болон Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэгдсэн төлөвлөгөөг баталж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

48.5.Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

48.6.Худалдан авах ажиллагааг төлөвлөх журмыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ зүйлийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

49 дүгээр зүйл.Худалдан авах ажиллагааг тайлагнах

49.1.Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална.

49.2.Тендерийн хавтаст хэрэг дараахь баримт бичиг, материалаас бүрдэнэ:

49.2.1.худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, шаардлагатай бол тайлбар;

49.2.2.нээлттэй тендер шалгаруулалтаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгосон үндэслэл;

49.2.3.худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тухай товч тодорхойлолт, тендерийн баримт бичиг;

49.2.4.захиалагч, тендерт оролцогчтой харилцсан албан бичиг;

49.2.5.тендерт оролцогчдын ирүүлсэн тендер;

49.2.6.тендерийн нээлтийн тэмдэглэл, үнэлгээний дүгнэлт, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж;

49.2.7.тендер шалгаруулалт амжилтгүй болсон, эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл;

49.2.8.гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр, гэрээ;

49.2.9.тухайн тендер шалгаруулалттай холбоотой бусад баримт бичиг;

49.2.10.гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг.

49.3.Энэ хуулийн 49.1-д заасан баримт бичиг, материалтай төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хууль, хяналтын эрх бүхий байгууллага, албан тушаалтан танилцах эрхтэй.

49.4.Тухайн тендер шалгаруулалтад оролцсон этгээд бичгээр хүсэлт гарган энэ хуулийн 49.2.2, 49.2.6, 49.2.7, 49.2.8-д заасан баримт бичиг, материалтай танилцаж болно.

49.5.Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

49.6.Тайлагнах журмыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

49.7.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 49.5 дахь хэсэгт заасны дагуу ирүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн дүгнэж, дараа жилийн эхний улиралд Засгийн газарт тайлагнана.

49.8.Засгийн газар жил бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланд Засгийн газрын худалдан авах ажиллагааны үр дүнг тусгана.

50 дугаар зүйл.Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагчийн үүрэг

50.1.Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих болон бусад үүрэгтэй оролцож байгаа төрийн албан хаагч дараахь үүрэг хүлээнэ:

50.1.1.шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх;

50.1.2.төрийн ашиг сонирхлыг дээдлэх;

50.1.3.хувийн ашиг сонирхлын үүднээс хууль бус санал тавих, хүлээж авах зэрэг зөрчил, хууль бус үйлдэл гаргахгүй байх;

50.1.4.тендерт оролцогч гэр бүлийнх нь гишүүн, эсхүл тендерт оролцогч хуулийн этгээдэд гэр бүлийнх нь гишүүн ажилладаг буюу цалин хөлс авдаг зэрэг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй нөхцөл байвал өөрийн шууд харъяалан удирдах албан тушаалтанд мэдэгдэж, тухайн тендер шалгаруулалтыг зохион байгуулах ажиллагаанд оролцохгүй байх;

50.1.5.тендерт оролцогч нь хээл хахууль санал болгох, дарамт шахалт үзүүлэх зэргээр тендер шалгаруулалтын дүнд нөлөөлөхийг оролдол энэ тухай өөрийн шууд харъяалан удирдах албан тушаалтан, хууль, хяналтын байгууллагад нэн даруй

51 дүгээр зүйл.Бүртгэлийн тогтолцоо

51.1.Тендерт оролцогчдын хүрээг өргөжүүлэх, өрсөлдөөнийг дэмжих, захиалагчийг мэдээллээр хангах зорилгоор энэ хуульд заасан журмын дагуу худалдан авах ажиллагаанд оролцохыг сонирхогч хуулийн этгээд, иргэний бүртгэлийг холбогдох төрийн захиргааны төв байгууллага тухайн Засгийн газрын гишүүний эрхлэх хүрээний асуудлаар хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

51.2.Энэ хуулийн 51.1-д заасан бүртгэл хөтөлх журмыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

51.3.Хуулийн этгээд, хувь хүн бүртгүүлэх хүсэлтээ үйл ажиллагааны чиглэл, чадвар, туршлагын талаархи мэдээллийн хамт өөрөө болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан бүртгэх байгууллагад хэдийд ч гаргаж болно.

51.4.Тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээд бүртгэлд хамрагдсан, эсхүл хамрагдаагүй нь тухайн тендер шалгаруулалтад энэ хуульд заасан журмын дагуу оролцох түүний эрхийг хөндөхгүй.

51.5.Тендер шалгаруулалтын онцгой журмыг хэрэглэх үед тодорхой тооны тендерт оролцогчийг урихдаа захиалагч бүртгэлд хамрагдсан хуулийн этгээд, хувь хүний талаар мэдээлэл авч болно.

51.6.Бүртгэл хөтөлхдөө дараахь нийтлэг шаардлагыг хангасан байна:

51.6.1.бүртгэлийг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан чадавхийн шалгуурт үндэслэн зохиох;

51.6.2.бүртгэлд хамрагдах хүсэлт гаргагч этгээд ижил нөхцөлөөр хангагдсан байх;

51.6.3.бүртгүүлэх хүсэлтийг бичгээр гаргах;

51.6.4.бүртгэлд хамрагдсан этгээдийн хүсэлтийн дагуу зохих нэмэлт, өөрчлөлтийг бүртгэлд тухай бүр тусгаж байх;

51.6.5.сонирхсон этгээд бүртгэлтэй танилцах боломжтой байх;

51.6.6.бүртгүүлэх хүсэлтийг 1 сарын дотор шийдвэрлэх.

51.7.Хүсэлт гаргасан хуулийн этгээд, иргэн, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс хүсэлтийг тодруулах, нэмэлт тайлбар, тодруулгыг бүртгэх байгууллага шаардаж болно.

51.8.Бүртгэх байгууллага бүртгэл хөтөлхдөө дараахь журмыг баримтална:

51.8.1.өөрийн эрхлэх хүрээний асуудал тус бүрээр тендерт оролцогчийн чадавхийг үнэлэх үзүүлэлтийг тодорхойлох;

51.8.2.энэ хуулийн 51.8.1-д заасны дагуу чадавхийг үнэлэх үзүүлэлтийг тодорхойлсны дараа бүртгэл хөтөлх тухай үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх.

51.9.Чадавхийг үнэлэх үзүүлэлтийг тодорхойлохдоо тухайн асуудлаар мэргэшсэн мэргэжилтний, эсхүл энэ хуульд заасны дагуу сонгосон зөвлөхийн туслалцаа авч болно.

51.10.Бүртгүүлэх, бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг бүртгэх байгууллага хүлээн авахаас татгалзвал энэ тухайгаа зохих үндэслэлийн хамт хүсэлт гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

52 дугаар зүйл.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

52.1.Энэ хуулийн дагуу худалдан авах ажиллагааны талаар төрөөс хэрэгжүүлэх бодлого, арга зүй, хяналтын асуудлыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхэлж, дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

52.1.1.худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах;

52.1.2.худалдан авах ажиллагаатай холбоотой мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр захиалагчийг хангах;

52.1.3.худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, аргачлал, жишиг баримт бичгийн төсөл, цахим тендер шалгаруулах журам, тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам, цахим худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам, худалдан авах ажиллагаанд мэдээллийн технологи, цахим хэрэгслийг нэвтрүүлэх нөхцөл, журам батлах;

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

52.1.4.худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг жил бүр Засгийн газарт тайлагнах;

52.1.5.захиалагч худалдан авах ажиллагаанд зохих журмыг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьж, шинжилгээ, үнэлгээ хийх;

52.1.6.захиалагчийн ирүүлсэн тайланг нэгтгэн, улсын хэмжээний худалдан авах ажиллагааны талаархи мэдээллийн сан бүрдүүлэн хөтөлх, нэгдсэн тоо баримт, мэдээлэл гаргах;

52.1.7.энэ хуульд заасны дагуу тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журмыг батлах;

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

52.1.8.хууль, хяналтын байгууллагын хүсэлтээр энэ хуулийн хэрэгжилттэй холбогдуулж тодорхой асуудалд зөвлөмж, тайлбар гаргаж өгөх;

52.1.9.энэ хуулийн 53.1-д заасны дагуу ирүүлсэн саналыг хянан үзэж, гэрээ байгуулах зөвшөөрөл өгөх;

[/Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон/](#)

52.1.10.энэ хуулийн 55 дугаар зүйлд заасан шинжээчдийг сургаж, бүртгэл хөтлөх;

[/Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон/](#)

52.1.11.худалдан авах ажиллагааны чиглэлээр явагдах сургалтын түвшин, чанар, стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтоох, сургалтыг зохион байгуулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтыг зохион байгуулах журмыг батлах;

52.1.12.худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд түгээх зорилготой цахим хуудас хөтлөх, түүнд тендерийн урилга, бусад мэдээлэл тавих арга, хэлбэрийг тогтоох;

52.1.13.худалдан авах ажиллагааны асуудлаар олон улсын байгууллага, гадаад улсын бусад байгууллагатай хамтран ажиллах, энэ чиглэлээр олгосон техник туслалцааг төлөвлөх, зохицуулах;

52.1.14.энэ хуулийн 14.5-т заасан тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх, хяналт тавих, мэдээлэх;

52.1.15.захиалагчийн үйл ажиллагаа, гэрээний биелэлт, чанарт явцын болон гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ, аудит хийх журмыг тогтоох.

[/Энэ заалтыг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

[/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

52.1.16.хуульд заасан бусад бүрэн эрх.

52.2.Худалдан авах ажиллагаанд мэдээллийн технологи, цахим хэрэгслийг нэвтрүүлэх нөхцөл, журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

52.3.Хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагыг энэ хуулийн 35-39 дүгээр зүйлд заасны дагуу сөнгөн шалгаруулж, захиалагчийн үйл ажиллагаа, гэрээний биелэлт, чанарт явцын болон гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ, аудит хийлгэж болно.

[/Энэ хэсгийг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

52¹ дүгээр зүйл.Худалдан авах ажиллагааны улсын байцаагч

52¹.1.Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад байна.

[/Энэ хэсэг т 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

52¹.2.Худалдан авах ажиллагааны улсын байцаагч нь худалдан авах үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

52¹.2.1.энэ хуулийн 14.1.4, 14.1.6-д заасан нөхцөл үүссэн нь тогтоогдсон тендерт оролцогчийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах тухай санал гаргах;

[/Энэ заалтад 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

52¹.2.2.энэ хуулийн 57.2-т заасан зөрчил гаргасан албан тушаалтныг төрийн албанаас чөлөөлүүлэх тухай дүгнэлт гаргаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

52¹.2.3.энэ хуулийн 42 дугаар зүйлд заасан хүчин төгөлдөр бус гэрээг цуцлах;

52¹.2.4.гэрээний үүргийг гуравдагч этгээдэд захиалагчийн зөвшөөрөлгүйгээр шилжүүлсэн, тендерийн баримт бичигт урьдчилан заасан хувь хэмжээнээс хэтрүүлэн төлбөр хийсэн гэрээг цуцлах.

[/Энэ зүйлийг 2011 оны 6 дугаар сарын 9-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

52¹.3.Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм болон тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

53 дугаар зүйл. Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний чиг үүрэг

53.1.Энэ хуулиар эрх олгосон худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

[/Энэ хэсгийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ хэсэг т 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

53.2.Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий нэгжтэй байна.

53.3.Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай, дүүргийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг дүүргийн Засаг дарга нийслэлийн Засаг даргатай тус тус зөвшилцөн томилж, чөлөөлнө.

[/Энэ хэсэг т 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан/](#)

[/Энэ хэсэг т 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

53.4.Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын болон нэгжийн дарга нь ял шийтгэлгүй, төрийн албанд 10-аас доошгүй жил, үүнээс худалдан авах ажиллагааны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байна.

[/Энэ хэсэг т 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан/](#)

[/Энэ хэсэг т 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

53.5.Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуульд заасан захиалагчийн эрх, үүргээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

[/Энэ хэсэг т 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан/](#)

[/Энэ хэсэг т 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

53.5.1.худалдан авах ажиллагааны нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;

53.5.2.Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулах;

53.5.3.худалдан авах ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, саналаа төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

53.5.4.худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд түгээх цахим хуудас хөтлөх, түүнд тендерийн урилга, бусад мэдээлэл тавих арга, хэлбэрийг тогтоох, боловсронгуй болгох;

53.5.5.захиалагч болон тендерт оролцогчдыг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, тэдэнд сургалт зохион байгуулах;

53.5.6.Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чадавх, техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг сайжруулах асуудлыг нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх;

53.5.7.энэ хуулийн 5.1.23-т заасан ерөнхий гэрээг байгуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

53.5.8.худалдан авах ажиллагааны үйл ажиллагаатай холбоотой хуульд заасан бусад чиг үүрэг.

53.6.Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

[/Энэ хэсэг т 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан/](#)

[/Энэ хэсэг т 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

53.7.Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь өөрийн гүйцэтгэх ажлын тодорхой хэсгийг хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нийт зарлах тендерийн 20-оос доошгүй хувийг цахим худалдан авалтын хэлбэрээр зохион байгуулна.

[/Энэ зүйлийг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ хэсэг т 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан/](#)

[/Энэ хэсэг т 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

ДОЛДУГААР БҮЛЭГ

МАРГААН ШИЙДВЭРЛЭХ, ХАРИУЦЛАГА

54 дүгээр зүйл.Захиалагчид гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

54.1.Тендер шалгаруулалттай холбогдуулан хүлээсэн үүргээ захиалагч зөрчсөн гэж үзвэл тендерт оролцогч энэ тухай мэдсэнээс

хойш ажлын 5 хоногийн дотор захиалагчид бичгээр гомдол гаргаж болох бөгөөд гомдолд зөрчлийг нотлох баримтыг хавсаргана.

54.2.Захиалагч гомдлын агуулгыг бүх тендерт оролцогчид мэдэгдэж, холбогдох шийдвэрээр эрх ашиг нь хөндөгдөж болох тендерт оролцогчийг гомдол барагдуулах ажиллагаанд оролцохыг урина.

54.3.Энэ хуулийн 54.2-т заасан оролцогч уг ажиллагаанд оролцоогүй тохиолдолд тухайн асуудлаар цаашид гомдол гаргах эрхгүй.

54.4.Захиалагч гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор хянан шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэрт гомдлыг хүлээж аваагүй бол түүний үндэслэл, гомдлыг хүлээн зөвшөөрсөн бол түүнийг барагдуулах арга хэмжээ тусгасан байна.

54.5.Нийтийн эрх ашгийг хамгаалах үүднээс тендер шалгаруулалтыг зогсоолгүйгээр үргэлжлүүлэх шаардлагатай гэж захиалагч шийдвэрлэснээс бусад тохиолдолд гомдол ирснээс хойш захиалагч гэрээ байгуулах эрх олгож болохгүй.

54.6.Энэ хуулийн 54.5-д заасны дагуу тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэх шийдвэр гаргасан бол холбогдох үндэслэлийг тухайн шийдвэрийг хэрэгжүүлэхээс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө гомдол гаргагчид албан ёсоор мэдэгдэнэ.

54.7.Гэрээ байгуулах эрх олгосноос хойш ирсэн гомдлыг захиалагч хүлээж авахгүй.

55 дугаар зүйл.Захиалагчийн шийдвэрт гомдол гаргах

55.1.Тендерт оролцогч нь энэ хуулийн 11.2-т заасныг зөрчсөн болон тендерийн баримт бичиг бэлтгэх явцад өрсөлдөөнийг хязгаарласан ямар нэгэн зөрчил гарсан гэж үзвэл гомдлоо тендерийн нээлт хийхээс ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт, захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, эсхүл гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг зөвхөн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус ажлын 5 өдрийн дотор гаргана.

[/Энэ хэсгийг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ хэсэг т 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

55.2.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар энэ хуулийн 55.1-д заасан гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ. Шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар тендерт оролцогч дахин гомдол гаргасан тохиолдолд хүлээн авахаас татгалзана.

[/Энэ хэсгийг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

55.3.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гомдлыг авч хэлэлцээд захиалагч энэ хуулийг зөрчсөн гэж үзвэл дараахь шийдвэр гаргана:

[/Энэ хэсэг т 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/](#)

55.3.1.энэ хуулийг зөрчсөн захиалагчийн үйлдэл буюу шийдвэрийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүчингүй болгох, өөрчлөх;

55.3.2.тухайн асуудалд хуулийн ямар заалт хэрэглэхийг заах;

55.3.3.зөрчлийг арилгасны үндсэн дээр тендер шалгаруулалтыг явуулахыг захиалагчаас шаардах.

55.4.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гомдлыг хянан хэлэлцэж шийдвэрлэх хүртэлх хугацаанд захиалагчийн гаргасан шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг дараахь тохиолдолд түр түдгэлзүүлэх шийдвэр гаргаж болно:

[/Энэ хэсэг т 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2011 оны 6 дугаар сарын 9-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/](#)

55.4.1.тендерт оролцогчийн гомдлыг хангах нь илүү үндэслэлтэй байгаа бол;

55.4.2.түдгэлзүүлээгүй тохиолдолд тендерт оролцогчид их хэмжээний хохирол учрахаар бол;

55.4.3.түдгэлзүүлэх нь төрийн эрх бүхий байгууллага, эсхүл захиалагч болон бусад тендерт оролцогчдод илтэд хохиролтой биш бол.

55.5.Энэ хуулийн 53.1-д заасны дагуу гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон тендер шалгаруулалтад гаргасан гомдлыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянахдаа шинжээчдийн багаар дүгнэлт гаргуулах бөгөөд уг байгууллагын шийдвэр нь шинжээчдийн багийн гаргасан дүгнэлтэд үндэслэнэ.

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

55.6.Шинжээчдийн баг хөндлөнгийн гурван шинжээчээс бүрдэх бөгөөд тэдгээрийг гомдол гаргаснаас хойш 3 хоногийн дотор дараахь журмаар сонгоно:

55.6.1.гомдол гаргагч, захиалагч тус бүр нэг шинжээчийг сонгох;

55.6.2.гомдол гаргагч, захиалагчийн сонгосон шинжээч нар төхирөлцөн гурав дахь шинжээчийг сонгох.

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон/](#)

55.7.Талууд шинжээчийг сонгож чадаагүй бол төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төдгөөрийн нэрийн өмнөөс сонгож болно.

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон/](#)

55.8.Шинжээчдийн багийн ажиллах болон шинжээчийн эрх олгох журмыг Засгийн газар батална.

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон/](#)

55.9.Тендерт оролцогчдын гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ хуулийн 20.7.3-т заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох дээд хэмжээ 20 сая төгрөгөөс хэтрэхгүй байна. Гомдлыг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол тендерийн баталгааг буцаан олгоно.

[/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

55.10.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдол хянан шийдвэрлэх хугацаанд энэ хуулийн 29.1-д заасан хугацаа түр зогсоно.

[/Энэ хэсгийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

56 дугаар зүйл.Шүүхэд гомдол гаргах

56.1.Гомдлыг энэ хуулийн 55.2-т заасан хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл гаргасан шийдвэрийг нь эс зөвшөөрвөл тендерт оролцогч нь шүүхэд гомдол гаргаж болно.

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

56.2.Тендер шалгаруулалтад холбогдсон гомдлыг гэрээнд гарын үсэг зурснаас хойш зөвхөн шүүхэд гаргана.

56.3.Тендер шалгаруулалттай холбогдох гомдлыг хүлээн авсан шүүх энэ хуулийн 55.4.1-55.4.3-т зааснаас бусад тохиолдолд төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийг түдгэлзүүлэхийг хориглоно.

[/Энэ хэсгийг 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

57 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

57.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

57.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

[/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

58 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

58.1.Энэ хуулийг 2006 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ